

## Улс төрийн лидерийн имиж бүрдүүлэлт ба технологи

### Image formation of Political leaders and technology

#### Уртнасангийн Батцэрэн<sup>1</sup>

Доктор (Ph.D), сургалтын менежер  
Удирдлагын Академийн  
Төрийн албаны сургууль  
[battserenu@gmail.com](mailto:battserenu@gmail.com)

#### Battseren Urtnasan

Doctor (Ph.D),  
Training manager,  
School of Civil Service,  
Academy of Governance  
[battserenu@gmail.com](mailto:battserenu@gmail.com)

#### Хураангуй

Тус сэтгүүлийн өмнөх дугаарт улс төрийн лидерийн имиж бүрдүүлэлтийн зарим нэгэн ойлголт болох лидерийн имиж, имиж ба харизм, зориг ба омгорхол, ялагчийн имижийн талаар товч тайлбарласан билээ.

Өгүүлэлдээ дээрх сэдвийн үргэлжлэл болох улс төрийн лидерийн тойрон хүрээлэгчид, Улс төрийн лидерийн баг, улс төрчийн би концепци, нэр дэвшигчээс улс төрийн лидер хүртэл, улс төрийн лидерийн манлайлал, улс төрийн лидер имижээ хайрцаглах гэсэн ойлголтуудын талаар товч тайлбарлан өгүүлэх болно.

**Түлхүүр үг:** улс төрийн лидер, имиж, баг, нэр дэвшигч, сонгууль, сонгогч харизм, омгорхол, би концепци, манлайлал, имижмейкер

#### Abstract

In the previous issue of the magazine, some concepts of political leader's image formation such as leader's image, image and charisma, courage and bravery, and winner's image were briefly explained.

In this article, as a continuation of the above topic, I will briefly explain the concepts of political leader's entourage, political leader's team, politician's self-concept, from candidate to political leader, political leader's leadership, and framing the image of a political leader.

**Keywords:** political leader, image, team, candidate, election, voter charisma, self-concept, leadership, image maker

## I. Оршил

Манай улсад улс төрийн лидерийн имиж бүрдүүлэлтийн үйл явц нь төлөвших шатандаа явж буй юм. Тухайлбал, улс төрд шинэ хүмүүс, шинэ хөдөлгөөн, намууд орж ирсээр байна. Улс төрд орж ирж буй хүнд шаардлагатай мэдлэгийг шинээр эзэмшиж, түүнд суралцах дадал, улс төрчийн болон түүний багийн хувьд улс төрийн соёлын түвшингээ дээшлүүлэх тал дээр явуулах байнгын нарийн няхуур ажиллагаа нь бидний амьдарч буй нийгэм, нийт улс орны хувьд төдийгүй бүх дэлхийд томоохон ач холбогдолтой юм.

---

<sup>1</sup> © Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

Улс төрийн имиж нь олон нийтийн ухамсарт төлөвшсөн шинж чанартай сэтгэл хөдлөлөөр тодорхойлогддог улс төрийн лидерийн дүр төрх юм. Имижийн төлөвшилт нь гэнэт ухамсаргүй юмуу эсвэл ухамсартай явагддаг. Ухамсартайгаар гэвэл улс төрчийг хүмүүсээс хүлээн зөвшөөрөх онцлогийг нягтлан судалснаар түүний таатай дүр төрхийг бүрдүүлэх шинэ стратеги тактикийг боловсруулах явдал юм.

Имиж бүрдүүлэлтийг нийгмийн саналыг илэрхийлдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлгүйгээр бүрдүүлэх боломжгүй. Улс төрчийг “ил гаргахгүй”, “нийтлэхгүй”, хаана ч үгийг нь хэлүүлэхгүй байх тохиолдолд тэрээр зөвхөн улс төрийн үзэл бодолтой нэгэн иргэн л гэхээс өөр юмгүй. Тэр битгий хэл нийгэмд чухал үйлс бүтээснийг хэвлэл мэдээллээр цаг тухайд нь мэдээлэхгүй өнгөрөөд, сонгогчид түүний амжилтад талархахгүй, түүнээс амьдралын тулгамдсан асуудлын талаар асуухгүй байх тохиолдолд тэрээр “улс төрөөс ангид” байна гэж хэлж болох юм.

## **II. Судалгааны арга зүй**

Лидер зарим үйлдлээрээ хоцорч буруу үйлдэл хийсэн ч байсан имижийн эрчим нь хадгалагдсаар, дэмжигдсээр байдаг. Имиж дээр үр ашигтай ажиллахын тулд нэр дэвшигчийн имижийн оношлогооны ба нэртэй улс төрчдийн имижд өгөх шинжээчийн үнэлгээний тусгай арга зүй шаардагддаг. Зарим нэгэн ном, зохиолд дурдагдсан мэдээлэл нь имижейкерийн хийсэн хамгийн шинэлэг боловсруулалтад тулгуурладаг. Өнөөгийн улс төрийн орчин дахь үйл явцыг өөрийн улс орны болон имиж бүрдүүлэлтийн технологи өндөр хөгжсөн манай улсын хойд хөрш орны судлаачдын үзэл баримтлалыг судлан, ажиглаж өөрийн бодлыг энэхүү үргэлжлэл болох хоёр дахь өгүүлэлдээ дээр дурдсан дэд сэдвүүдийн хүрээнд товч тусгахыг зорив.

## **III. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг**

*Улс төрийн лидерийн тойрон хүрээлэгчид.* Улс төрч нь хүнийг сайн таньж мэдээгүйгээс өөрийгөө мэргэжилтнүүдээр бус харин хувийн ашиг, сонирхолдоо хөтлөгдсөн, өөрийг нь тойрон хүрээлэгч нараар бүрдүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, зарим нь өөрийгөө чадваргүй хүмүүсээр тойрон хүрээлүүлдэг. Ийм хүрээлэлд байгаа улс төрч нь хэт завгүй ба халдашгүй болж эхэлдэг. Тухайн тохиолдолд түүнд оршин тогтнох магадлал улам багасдаг. Хэрэв улс төрчийг тойрон хүрээлэгчид нь хөгжиж боловсрохыг эрмэлзэн шилдэг бүхнийг олж авахын төлөө суралцах аваас боломж бүрддэг.

Улс төрчийн хамгийн чухал шинжийн нэг бол түүний зоригжуулдаг жирийн хүмүүсээс лидер төрөх явдал юм. Нөгөөтэйгүүр, улс төрчийг ч тойрон хүрээлэгчид нь зоригжуулах ёстой. Хэрэв ийм зүйл байхгүй бол цаашид бүх зүйл буруу сценариар явагдана: саналаа хэлэхээс айдаггүй, маргаан мэтгэлцээнд идэвхтэй оролцдог тойрон хүрээлэгчид нь улс төрийг зулгуйдан, улс төрчийг мэргэжилтнүүдээс нь салган түүнийг хамгийн хамгийн гэж шударга бус үнэнээр хэлэх явдал гардаг. Үнэн бодит эргэх холбоо байхгүй ба зохих шийдвэр боловсруулах боломжгүй байх нь ялагдал хүлээх нөхцлийг бүрдүүлдэг.

Тойрон хүрээлэгчдийн шалгуур нь улс төрчийг орлох тохиолдолд түүний өмнөөс уулзалт зохион байгуулж, гэрээ хэлэлцээрийг сайн үр дүнд хүргэх чадвартай байхад оршино. Тойрон хүрээлэгчид хэдийн өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах нь өөрийг нь ч улс төрчийг ч эвгүй байдалд оруулах тохиолдол гардаг. Цаашилбал бүх зүйл үр дүнгийн чанар ба сонгогчдод түүний хэрэгцээ байгаа эсэхээс их шалтгаална. Хүмүүс амжилттай яваа улс төрч рүү илүү их тэмүүлдэг. Түүнд гэрээ хэлэлцээр хийх үйлчилгээг санал болгон хамтын ажиллагааны боломж бололцоо ба хэтийн төлөвийн тухай ярьдаг.

Улс төрчид бүх зүйл хэрэгтэй боловч тэрээр найруулагчийн нэгэн адил дүрээ нарийн хуваарилж, хамтын ажиллагааны арга барилаа төлөвлөх юмуу эсвэл түүнээс түр татгалзан, өөрийн цагаа нягт нямбай хуваарилах ёстой. Хэрэв улс төрч нь имижээ бүрдүүлж, ялалтаа тодорхойлуулдаг багаасаа сул дорой байж, багаа үнэлэхгүй бол “ялагч биш хохирогч” болдог ба тухайн ялалт нь удаан үргэлжлэхгүй.

Лидерүүд болон тэдний залгамжлагчдын хоорондын харилцан үйлчлэлийн үйл явц нь динамик ба бараг эцэс төгсгөлгүй байдаг. Лидер нь өөрийн байр сууриа байнга хадгалах ёстой. Түүнийг дагагчид нь лидерт хандах харилцаагаа зохицуулах юмуу эсвэл шинэ лидерийг сонгодог. Лидер нь албан тушаалаа хадгалж, дагагчдаа авч үлдэхийн тулд эрх дархаа батлах гэж өөрийгөө золиос болгодог эцэс төгсгөлгүй хувь тавилантай байдаг. Тэрээр амжилтанд хүрэхийн тулд төрөл бүрийн хэрэгслийн нөөцөд түшиглэн нөлөөлөх стратегийн янз бүрийн аргыг сонгох ёстой болдог. Жишээ нь: МАХН-ын дарга Н.Энхбаяр хүүхдээ өөрийн залгамжлагч болгон улс төрд оруулан улмаар 2021 онд МАН-тай нэгдэн 2021 оны УИХ-ын 28-р тойргийн нөхөн сонгуульд хүү Э.Батшугарыг МАН-аас нэр дэвшүүлж буй явдал нь дээрх ойлголтын тодорхой жишээ юм.

*Улс төрийн лидерийн багийг* сонгон шалгаруулах олон зарчим байдаг. Тухайлбал, хувь хүний үнэнч байдал эсвэл ажиллах чадвар, “чадварүй ч гэсэн миний хүн байна” буюу “ямар ч тохиолдолд түүнд итгэж болно” гэх мэтийн зарчим байдаг. Нэгэн цагт багаа хамгийн амжилттай сонгож чадсан хүн бол АНУ-ын агуу ерөнхийлөгч Франклин Рузвельт байв. Рузвельтийг ерөнхийлөгч байх бүх цаг хугацааны туршид багт нь хэдий өндөр цалин хөлстэй ажил санал болгосон ч түүнийг орхиогүй юм.

Ялалтанд хүрэх хамгийн сайн арга бол өөрийгөө “одод”-оор буюу нэртэй улс төрч, нийгмийн зүтгэлтэн нараар өөрийгөө хүрээлүүлэх явдал юм. Гэхдээ үүний тулд эр зориг, өөртөө итгэх итгэл, ур чадвартай байх шаардлагатай. Хүнийг татах чадвар нь улс төрийн лидерийн хамгийн том давуу тал. Оюуны өндөр чадавхтай улс төрч нь мэдээлэл сайтай шийдвэр гаргахдаа хамт олны оюунд түшиглэх шаардлагатай гэдгийг сайтар ойлгодог. Одоогийн байдлаар, “санал солилцох” аргын тусламжтай шаардлагатай шийдлийг хайж олоод томъёолон боловсруулдаг олон арга байдаг. Үүнээс гадна, баг нь улс төрчөө хамгийн олон талын түвшнээр нь зохистойгоор танилцуулахыг шаарддаг. Тэдгээр нь зөвхөн голдуу тэгш эрхтэй байх төдийгүй дээд зэргийн зохих ёсны төлөөлөгчид байх ёстой.

Улс төрч нь нэг багтай ялалт байгуулдаг бол нөгөөтэй нь ялах бараг л боломжгүй байдаг. Өөрөөр хэлэхэд, нэг лидертэй баг нь ялалт байгуулах ба нөгөө нэгэнд нь ялагдах магадлалтай.

Имиж нь нийгмийн тодорхой бүлэг хүмүүсийн хүлээлтийг илэрхийлдэг юм. Гэхдээ имиж нь сонгуулийн кампаний үйл явцад өөрчлөгдөж болох юм. Яагаад гэвэл сонгуулийн кампани нь улс төрийн идэвхийн хамгийн оргил үе байдаг. Түүнийг амжилттай хийж чадвал ялагч болдог.

*Улс төрч ба “Би” концепцийн хувьд*, улс төрийн лидер нь ямар ч нөхцөл байдалд өөрийн гэсэн “Би” гэсэн зарчим, үзэл бодолтой явдаг. Түүний зан байдал өөрийгөө хэрхэн хүлээн авч, өөрийгөө харилцан ажилладаг бусад хүмүүстэй хэр зэрэг дүйцүүлэхээс их хамаарна.

“Би” концепци нь өөрөөр хэлбэл, хүн өөрөө хэн бэ гэдэг хэд хэдэн талтай байна. Түүнээс сонгоод Би гэсэн дүр төрх нь улс төрийн лидерийн өөрийгөө үнэлэх үнэлгээ ба нийгмийн баримжаа юм.

Америкийн судлаач Д.Оффер, Ч.Строзаер нарын үзэж байгаагаар улс төрчийн “Би дүр төрх” нь хүний өөртөө хүртээмжтэй хандах санаа бодол ба мэдрэмжийн нийлбэртэй тохирч байдаг байна. Эдгээр хүртэмж, санаа бодол, мэдрэмж нь их бага хэмжээгээр Би гэх дүр төрхөд илрэхдээ хоорондоо харилцан нягт холбоотой хэсэгт хуваагдсан байна. Үүнд:

- Биеийн Би нь биеийн эрүүл мэнд, бие бялдрын байдал ба сул дорой талынхаа талаарх улс төрчийн өөрийнх нь төсөөлөл байдаг. Ус төрчийн эрүүл мэнд нь түүний үйл ажиллагаанд саад болохооргүй тийм эрүүл саруул байх ёстой.
- Гэр бүлийн Би нь хувь улс төрчийн хувьд маш чухал элемент байдаг. Нас биед хүрсэн хүний зан байдалд гэр бүлийн хүмүүжил ихээхэн үүрэг гүйцэтгэдэг нь юуны өмнө сэтгэл зүйн оношлогоогоор маш тодорхой юм. Улс төрийн зарим лидерүүд нь урьдын шарх, зөрчлөө даван гардаг бол нөгөө нэг хэсэг нь үгүй.
- Нийгмийн Би гэдэгт улс төрийн лидер нь гэрээ хэлэлцээр хэрхэн хийх, хамт олныхоо сайн талыг илрүүлэхийн тулд тэднийг хэрхэн яаж урамшуулах зэрэгт суралцах ёстой. Тэр бусад орны удирдагчид заримдаа янз бүрийн дайсагнасан бүлэгтэй хамтран үр дүнтэй ажиллахын тулд хувь хүмүүсийн хоорондын харилцааны дадал, хэвшил, ур чадварыг ашиглах чадвартай байх ёстой.
- Сэтгэл зүйн Би нь улс төрийн лидерийн амьдралын чухал асуудал болох дотоод ертөнц, уран зөгнөл, хүсэл эрмэлзэл, бүтэшгүй мөрөөдөл, айдас, зөрчлийнхөө тухай төсөөллөө өөртөө багтаадаг.
- Зөрчлийг даван туулдаг Би нь улс төрийн лидер нь зөрчлийг бүтээлчээр даван туулах ба хуучин асуудалдаа шинэлэг шийдвэр олох чадварынх нь тухай төсөөлөлд оршдог. Лидер нь асуудлыг хүлээж авахын тулд хангалттай мэдлэг бүхий оюун ухаантай байх ёстой. Тэрээр улс төрийн шийдвэр гаргахдаа өөрөө өөртөө хангалттай итгэлтэй байж, энэхүү итгэлээ бусдаар итгүүлэх чадвартай байх ёстой.

Улс төрчөөс өөрийгөө үнэлэх үнэлгээ нь түүний улс орны дотоод болон гадаад улс төрийн чиглэлд маш чухал ул мөрийг үлдээдэг байна. Хэрэв түүний өөрөө өөрийгөө үнэлэх үнэлгээ амьдралынх нь туршид доогуур байсан бол

түүний өөрийгөө байнга голж байсан нь түүнийг улс төрийн гадаад ба дотоод бодлогын хүрээнд бүр шинэ шинэ саадыг даван туулахад түлхэц болдог тэр л хөдөлгөх хүчин нь байдаг. Жишээ нь: Ленин, Сталин, Кеннеди, Рейган нар ба бусад нь ийм л хүмүүс байв. Тэд ялалт болгондоо өөрсдийгөө үнэ цэнэтэй хүмүүс гэдгээ байнга баталж байв. Гэхдээ тэдний даван туулсан бүх саад бэрхшээл нь тэднийг хэдийн баярлуулахаа байсан байв. Тэгээд ч тэд ач холбогдолтой гэдгээ бүрэн батлахын тулд шинэ зүйлийг бүтээхээр тэмүүлж байсан.

Өөрийгөө хэт үнэлдэг улс төрийн лидерүүд улс төрчийн ба ерөнхий командлагчийнхаа хувийн зан чанарыг хэт үнэлснээр олон улсын тавцанд явуулж буй гадаад, дотоод бодлого ба нийтийн хариу үйлдлээ ихэнхдээ анзаардаггүй байна. Тэд хувийн амжилтандаа ташууран шүүмжлэлийг ууртай өширхүү атаархагчдад хандуулсан зүйл мэтээр үздэг.

Улс төрийн лидерийн өөртөө хангалттай итгэх итгэл нь улс төрийн тавцанд хамтрагчийн хамгийн сайн жишээ юм. Тэдний гадаад, дотоод улс төрийн бодлого өөрийгөө батлах хүслээр өдөөгддөггүй, тэдгээр болон тэдгээрийн үйл ажиллагаа хоорондын эргэх холбоо итгэлтэй ажилладаг. Улс төрийн чадвараа адил тэнцүү үнэлдэг лидер нь бусад лидерээ ч өндрөөр үнэлэн тэдэнд хүндэтгэлтэй ханддаг. Өөрийн өндөр үнэ цэнийг хатуу ойлгон хамтран ажиллах хүнээс өөрийгөө дорд үзэлгүй, түүнийг дорд үзэх, гомдоон хуурахаас үл эмээдэг тийм л лидер тавьсан зорилтоо биелүүлэх бодлого явуулж чадсанаар харилцан ашигтай ажиллана.

*Нэр дэвшигчээс улс төрийн лидер хүртэл.* Эдийн засагтай адилтгаж үзвэл ардчилсан сонгууль нь сонгуулийн хөтөлбөрөөр эрх бүхий байгууллагад нэр дэвшигчид нь сонгогчдын итгэл ба засгийн эрх мэдлийг сольж авдаг улс төрийн зах зээл юм. Чөлөөт нийгмийн улс төрийн зах зээл нь аль ч зах зэлийн нэгэн адил нэр дэвшигчдийг эрх бүхий байгууллагад өрсөлдүүлэхгүй байх боломжгүй юм. Харин улс төрийн өрсөлдөөн нь улс төрийн зар сурталчилгаагүй боломжгүй.

Сонгогчдод үр ашигтай нөлөөлөх тал дээр зөв бэлтгэж боловсруулсан ухуулах хуудасны кампанит ажил нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн электрон болон хэвлэлийн ухуулгаас илүү давуу талтай. Имижийн агуулгын үндсийг нийгмийн эрэлт хэрэгцээг хангахуйц лидерийн чадвар бүрдүүлдэг юм.

Өөр нэг чадвар болох харилцааны ур чадвар нь үзэл бодлынхоо үнэн зөв гэдэгт бусдыг ятгах чадвар нь мөн адил чухал ач холбогдолтой юм. Имиж нь - улс төрийн онцгой байр суурийн билэг тэмдэг юм. Тиймээс имиж нь - улс төрийн лидерт зайлшгүй шаардлагатай чанарын нэг юм. Имиж нь - нэр дэвшигчийн улс төрийн нүүр царай, сонгогчдоо мэргэжлийнх нь үүднээс ойлгуулах, түүний бусдаас ялгарах бодгаль чанарыг нэгэн зэрэг тодруулах чадварын илрэл юм.

Улс төрийн имиж бүрдүүлэх тухай ярихдаа юуны өмнө сонгогчиддоо ойлгомжтой байх, тэдний итгэлийг олж авах тухай голчлон ярьж байна. Нэртэй улс төрчид нь тодорхой бүлэг сонгогчдын хувьд сэтгэл татам хувь хүний болон ажил хэрэгч хүний зан чанарын өвөрмөц цуглуулга байдаг. Хэрэв нэр дэвшигч нь сонгуульд ялсан бол, энэ нь ажил хэрэгч улс төрчөөс олон нийтийн санаа

бодол болон улс төрийн хамтын нийгэмлэгт өөрийн статусаа үнэлэн бэхжүүлж чадах имиж сонгосны гэрч гэсэн үг.

*Улс төрийн лидерийн манлайлал* бол бүлэг хүмүүсийн үзэгдэл юм. Лидер нь “биеэ даан” ганцаараа шавь нараасаа гадуур орших боломжгүй. Тэрээр гагцхүү дэмжин дагагчидтай байхдаа л байлдан дагуулагч лидер болдог. Тиймээс лидер болон түүний шавь нар хоорондын харилцаа нь удирдлагын үндсэн бүрэлдэхүүн гол хэсэг юм. Лидер болон шавь нарын хоорондын харилцааны гол онцлог нь эрх мэдэлтэй холбоотой байдаг харилцаа юм.

Нэг хүн нөгөөгөө захирах боломж тохиолдолд нөгөө нь тухайн тушаалыг бүр илүүтэй биелүүлэх үед тухайн хүнийг бусдыг захирах эрхтэй байдаг тухай бид ярьдаг. Гэсэн хэдий ч энэ нь үйл ажиллагаа биш харин ч үйл ажиллагаа явуулах боломж ба хүмүүсийн хооронд бүрдсэн харилцааг илүүтэйгээр тодорхойлдог зүйл юм. Эрх мэдэл нь чадамжтай байдаг яагаад гэвэл эрх мэдэлтэй хүн нь тушаахгүй байсан ч болно. Эрх мэдлийн харьцаанд үндэслэсэн үйл ажиллагаа тэртээ тэргүй явагддаг, нэг хүн нөгөөгөө эр зоригийнх нь дагуу аливаа зүйлийг хийхийг шаардсанаар болдог юм бол сэтгэл зүйн шинжлэх ухаанд үүнийг нөлөөлөл гэдгээр тодорхойлдог.

- Нийгмийн нөлөөлөл. энэ нь нэг болон бүлэг хүмүүсийн зан байдал ба бусдын байдал өөрчлөгдөхийг хэлнэ. Нөлөөлөл нь хүмүүсийн хоорондын харилцан үйл ажиллагааны үйл явц бөгөөд сэтгэл зүйн үүднээс манлайллын суурь нь болдог. Лидер болчхоод цаашид байсаар байхын тулд хүн нь бодит эрх мэдэлтэй байх нь гол зүйл биш. Эрх мэдлийг ашигласнаар бусад хүмүүст байнга нөлөөлж, санаа бодлоо тэдэнд тулган өөрийн шийдвэрээ тэдний гараар хийлгэх ба эдгээр хүмүүсийг өөрийн аялдан дагагч болгоход оршино. Манлайллын бие даасан хоёр хэв маягийг тодорхойлдог: Нэг нь үйл явдалд оролцогч болгон хоорондоо шууд харилцах боломжтой байдаг бичил бүлэгт “нүүр тулан” манлайлах боломжтой. Харин нөгөө нь олон түмнийг манлайлах буюу лидерүүдтэй байх.
- Удирдан манлайлах: нь өөрийн гэсэн онцлогтой. Түүний гол онцлог нь лидерүүд байлдан дагуулагчидтай харилцахдаа шууд харилцааг бараг үүсгэдэггүй бөгөөд ерөнхийдөө тухайн харилцаа нь шууд бус аргаар явагддаг. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин уг харилцан үйлдэл болдог төдийгүй лидерийн имиж гэдэг нь дагагчдад нөлөөлнө гэсэн үг. Чухамхүү тухайн имиж буюу нийтэд зориулагдсан лидер гэсэн ойлголт нь тухайн тохиолдолд манлайлагчийн үүрэг гүйцэтгэж, ард түмнийг зоригжуулснаар тэдний хүсэл мөрөөдөл түүн рүү хандахыг хэлнэ. Лидерийн тухайн имиж улс төрчөөс сонгогчидтой биеэрээ тогтоосон харилцаа холбооны үр дүнд бий болдог. Ийм тохиолдолд манлайллын сэтгэл зүйн уламжлалт асуудал болох хувь хүний зан байдлын чухам ямар шинжүүд /лидерт шаардлагатай шинж чанар/ ба хувь хүний ямар хэв маяг аливаа тухайн нөхцөл байдалд /манлайлагчийн нөхцөл байдлын онол/ шаардагдах явдал хойшоо тавигддаг.
- Нийтэд зориулагдсан лидер: нь зохиомол дүр төрхийн хувьд нийтийн хүлээсэн шаардлагад нийцсэн дурын шинжтэй байж болох юм. Хувь хүний хувьд лидер нь өөрөө манлайлагч болоход хувийн ямар шинж чанар шаардлагатай байх, “Би нийтэд үйлчлэх” дүр төрхийг бүтээхэд бүх бэрхшээлийг давж гарах чадвар, өөрийгөө нийтэд таниулах зэрэг асуудал нь нэн тэргүүнд тавигддаг.

*Улс төрийн лидер имижээ хайрцаглах* гэдэг нь лидерийн чиг баримжааны үндсэн хоёр хэв маяг байдаг. Үүнд: зорилгод чиглэгдсэн байх, бүлэг хүмүүсийн хооронд ээлтэй харилцаа тогтооход чиглэгдсэн сэтгэлийн хүсэл мөрөөдөл ба тавьсан зорилтоо хэрэгжүүлэх зэрэгт оршино.

Тухайн хоёр чиг баримжаа нь нэг лидерийн ч мөн бүлэг хүмүүсийн дунд ч хуваарилагдах боломжтой. Ийм маягаар шууд лидерүүдийн хэд хэдэн янз бүрийн хэв шинж бүрэлдэх төлөвтэй. Сонгуульд нэр дэвших албан ёсны байр суурьтай, тухайлбал ерөнхийлөгчийн албан тушаалтай, зайлшгүй хоёр л зорилт бий болдог. Үүнд: дэвшүүлсэн зорилтын талаар үйл ажиллагаа явуулах шаардлагатай зэрэгцээ өөрийнхөө сонгуулийн штаб бөгөөд дэмжигчидтэй хамтран ажиллах үйл ажиллагаа байдаг. Гэлээ гэсэн ч өндөр албан тушаалтай улс төрийн лидерийн хувьд байдал дахин дахин өөрчлөгдөх магадлалтай.

Улс төрийн лидер ба түүний байлдан дагуулагчдын шууд бус харилцааны шинжээс шалтгаалан лидерээс олон нийтэд нөлөөлөх хамгийн гол үр ашигтай нөлөөлөл нь хэвлэл мэдээлэл болдог. Түүгээр байлдан дагуулагчид нь хувийн харьцаа, сэтгэгдлээс үл хамаарна харин хэвлэл мэдээллээр бусдад зориулсан тодорхой үзэл бодлын- ил буюу ил бус - мэдээллээс түүний тухай төсөөлөл бүрддэг. Тухайн мэдээлэл нь лидерийн хэлсэн үг, биеэ авч яваа байдал, үйлдэл, улс төрийн билэгдэл гэх мэтээс бүрдэж болно.

Тухайн мэдээлэл нь хэзээ ч салангид ба нэг удаагийн байдаггүй. Тэд бие биенээ нөхсөнөөр хөгжүүлж, өөрсдийгөө өөрчлөх шинжтэй юм. Тэдгээрийн урсгал нь улс төрийн харилцаа холбооны үндэс болдог. Улс төрийн харилцаа холбоог байнгын нөлөөлөл гэж үзэж болно. Улс төрийн харилцаа холбоог үзэл бодлыг тайлбарлах, илрүүлэх гэдгээр ойлгох шаардлагагүй харин ч лидерээс гарч буй мэдээлэл, үйлдэл гэдгээр ойлгох нь илүү зохимжтой. Яагаад гэвэл улс төрийн харилцаа холбоо нь түүний гарт орохдоо “утга учрыг бий болгодог хэрэгсэл” болдог юм. Гэлээ ч гэсэн нийтийн тогтсон үзэл бодлоос хамааран утга учрыг бий болгохоос шалтгаалдаг бөгөөд нийтэд илгээсэн мессеж нь нийтийн ашиг сонирхолд нийцсэн байх ёстой.

Улс төрийн лидерийн хувьд нийтэд нөлөөлөх хэл ярианы хэрэгслээс гадна өөр хэрэгсэл бий. Эдгээр нь одоогоор эзэлж буй албан тушаалтай юмуу хүмүүсийг урамшуулах эсвэл тэдэнд хүчирхийлэл үзүүлэхтэй холбоотой байж болно. Түүнд үндэслэсэн нөлөөлөл нь лидер болон түүний байлдан дагуулагчдын хамтын харилцааны хамгийн чухал хүчин зүйл болдог.

*Улс төрийн лидерийн имиж бүрдүүлэх дүрэм* нь олон улсад болон манай улсад сонгуулийн кампанит ажил, сонгуулиас бусад цаг хугацаанд улс төрийн лидерүүд дараах байдлаар имижээ бүрдүүлж байна. Үүнд:

- Харилцаа холбоо: нь өнөөгийн улс төрийн үйл явцад сонгогчдод нөлөөлөх хамгийн хүчтэй бөгөөд найдвартай хэрэгсэл болдог гэдгийг байнга санах нь зүйтэй. Улс төрч нь энэхүү харилцаа холбооны тусалцаатайгаар өөрийн санал бодол, мэдрэмжийг нийтэд цацах төдийгүй өөрийн гэсэн дүр төрхийг бүрдүүлж, улс төрийн бодит нөхцөл байдлыг бий болгох чадвартай болдог;
- Улс төрчийн хувьд хамгийн чухал зорилго: нь сонгогчдод өөрийгөө зөв талаас харуулах зохимжтой арга барилыг боловсруулахад оршино. Бий болгосон имиж нь улс төрчийн хувь хүний бүхий л чанарыг илрүүлэхгүй ч гэсэн сонгогчдыг өөртөө татах шинж чанартай байх ёстой;

- Лидер хүн нэг талаараа бусдыг өөртөө татдаг: бол нөгөөтээгүүр тэднийг өөрөөсөө түлхдэг. Улс төрчийн гол зорилтын нэг нь өөрийн гэсэн дэмжигчийн тоог өсгөхөд оршино. Энэ үйл явцад хүмүүсийг ухамсаргүй болгож, түүнийг дэмжих үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр чухал болдог. Үүний тулд сэтгэл зүйн шинжлэх ухааны, театрын найруулагчийн арга барил ба театрын жүжигчний уран чадвар шаардагддаг;
- Өөрийгөө авч яваа байдлаа гарын хөдөлгөөнөөрөө хянах: үүнд анхаарах нь зүйтэй. Энэ нь утгыг биеийн хөдөлгөөнөөр илэрхийлдэг гол хэсэг болдог;
- Лидерийн имижээ олон өнгө аясыг оруулахыг хичээх: Өөрөөр хэлбэл, сонгогчдын сэтгэл хөдлөлд өөрийн гэсэн тодорхой хүмүүнлэгийн шинжийг тусгахыг эрмэлз. Сонгогчдын өмнө сэтгэл хөдлөлөө үзүүлэх, шударга байх, аливаа асуудлыг ил тодоор харилцан хэлэлцэх, тэдгээрийн санал бодолд хариулах чадвар нь хүмүүстэй ойр дотно болоход нь дэмжлэг болдог;
- Эрчим: гэдэг ойлголтыг улс төрчийн имижийг байнга шинэчлэн өөрчлөх утгаар тайлбарлаж болно. Цаг бүрт онцгой байж бусдын сонирхлыг татахуйц илүү ухаалаг гэж өөрийгөө харагдуулахыг хичээх нь эрчмийн гол утга оршдог. Түүний үйл ажиллагаа, үйлдэл хэт давтагдахаараа ойлгомжтой болох хандлагатай;
- Өөртөө шаардлагатай санал авах: иймийн тулд хэлэх үгээ зөв сонгож, зүйрлэл, ардын аман зохиолын хэллэг, үйлдэл гэх зэргээр нөлөөлөхийг хичээ. Тэдгээрийг өөртөө болон бусад хүмүүст зөв үйлдлээр харуулахын тулд өөрийгөө дайчил;
- Сэтгэл зүй: уг шинжлэх ухааны мэдлэгийг ашиглаарай. Улс төрийн лидерийн сэтгэл зүйн дүр зургийг сэтгэл зүйн болон зурхай судлалын бүтээлээс ашиглан бүрдүүлэхийг оролдоорой. Лидерийн давуу талыг онцгойлохын зэрэгцээ түүний дутагдлыг ч гэсэн давуу байдлаар харуулах;
- Улс төрчийг өөр болгох: Хэрэв улс төрч нь бага инээмсэглэдэг бол түүнийг инээмсэглэдэг болгохыг хичээ. Тэрээр хамтран зүтгэгч, сонгогчид, багийн гишүүдтэй харилцахдаа тэдгээрийг өөрийнхөө хамгийн дотны хүмүүс гэж ойлгож харьцах;
- Хэрэв улс төрч нь байнга инээмсэглэл: ийм байх тохиолдолд сонгогчдын бэрхшээлтэй асуудлын талаар дотноор ярилцан, тэднийг сонсох хэрэгтэй. Тэдний асуудлыг шийдвэрлэх ёстой гэдэгт хариуцлагатай хандаарай;
- Харилцагч: түүний харцыг эгцлэн ажиглаарай. Түүний харцнаас нүдээ бүү буруул. Түүнийг ойлгож, ээлтэй хандан сэтгэл санааг нь хуваалцаж, туслахын тулд өөрийн зөн совингоо идэвхжүүлэх;
- Өөрт тань итгэл: итгэл байхгүй ч гэсэн өөртөө итгэлтэй байхыг хичээ. Улс төрч хүн нь ямар үзэл бодлын төлөө тэмцдэг, тэр нь ямар хүмүүст хэрэгтэй, уг санааг хэн дагахыг тодоор ойлгох ёстой. Таны үзэл бодлыг хуваалцах хүн олон байвал та итгэлтэй байх үндэслэлтэй;
- Хүмүүсийг өөртөө татах: Санаагаа хэрэгжүүлэх практик үйлдэлд хүрснээр улс төрчдөд шаардлагатай жинхэнэ итгэлийг олж авна.
- Үг хэллэг: “Үгүй”, “завгүй” юмуу эсвэл “таныг хүлээж авах боломжгүй” гэдэг үгийг бүү хэл. Үүнийг зөвхөн чадвар муутай даргаас л сонсоно. Өөртөө хүмүүсийг, сонгогчдыг татахыг эрмэлздэг улс төрчидтэй уулзах цаг хэзээ ч олдоно. “Үгүй” гэх үгэнд хэд хэдэн хувилбар бий. Гэхдээ “үгүй” гэсэн тохиолдолд та сонгогчоо алдана;



- Сэтгэл хөдлөлөө хянах: Эерэг эмоци нь таны үйл ажиллагааны амжилтад хүрэх шат байж болно. Харин сөрөг тал нь таныг “дарж” эрмэлзлэл төрүүлэн эцэст нь бүтэлгүйтэхэд хүргэж болзошгүй.

Сонгуулиар оногдсон богинохон хугацаанд хүн бүрт имижээ бүрдүүлэх боломж олддоггүй. Сонгуулиар олгогдсон хугацаанд “ялагч” гэдэг имиж хүн бүрт оногддоггүй. Имижмейкерийн мэргэжил нь шүүх хуралд ялах ёстой өмгөөлөгчийн мэргэжилтэй ижил төстэй байдаг. Өмгөөлөгчийн ажлын ёс зүйн зарчим гэж бий. Гагцхүү имижмейкерийн ажлын ёс зүйн зарчим бага хэлэлцэгддэг.

### **Ашигласан материал**

1. Батцэрэн У. (2017). Улс төрийн лидерийн имиж бүрдүүлэлтэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг. Диссертаци. Уб.,
2. Гоулд Ф. (1994). Стратегическое планирование избирательной кампании. США.
3. Зверинцев А.Б. (2003). “Информационные и коммуникационные менеджмент, PR”. Уб.,